

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2-р сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi@audit.gov.mn](http://www.dornogovi@audit.gov.mn)

Дорноговь аймаг  
Сайншанд сум  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734  
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас:70523020  
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа  
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайшинд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2022.02.24 № 4-6/202

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2-Р СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Т.БАТТУЯА ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах,

010070415

санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 29.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,746.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,009.9 сая төгрөгийн 48 гүйлгээ, 152.6 сая төгрөгийн 22 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.1 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.0 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.0 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн "0" төгрөг, УБГэрчилгээ дээрх өмчийн дүн 270.0 сая байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн "14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын 3 ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актгүй байна. Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 10 зорилго, 35 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 90 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.2 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>114,068,338.54</b>	<b>166,011,138.84</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	29,389,596.80
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	29,389,596.80
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	29,389,596.80
31211	Төрийн сангийн харилцах	-	29,389,596.80
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	673,536.50	196,500.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	673,536.50	196,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	113,394,802.04	136,425,042.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	12,861,200.00
35110	Тусгай зориулалттай материал	-	12,861,200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	113,394,802.04	123,563,842.04
35410	Бичиг хэргийн материал	18,616,667.61	24,256,907.61
35420	Аж ахуйн материал	94,778,134.43	99,306,934.43
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,410,300,865.77</b>	<b>4,375,361,086.57</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,410,300,865.77	4,375,361,086.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,139,293,448.97	4,104,785,419.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,019,233,970.00	4,019,233,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(182,122,262.70)	(254,656,167.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	336,141,315.66	434,994,219.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,189,194.10)	(241,373,705.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	262,705,417.00	257,635,417.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(139,698,596.43)	(158,367,782.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,600,000.00	18,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,023,333.46)	(17,841,666.95)
39217	Ном	37,646,133.00	46,561,136.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	271,007,416.80	270,575,666.88
39301	Програм хангамж	2,497,000.00	2,497,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,489,583.20)	(1,921,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	270,000,000.00	270,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,524,369,204.31</b>	<b>4,541,372,225.41</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,524,369,204.31</b>	<b>4,541,372,225.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,524,369,204.31	4,541,372,225.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	270,000,000.00	270,000,000.00
51101	Өмч: - төрийн	270,000,000.00	270,000,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,185,665,151.35	3,202,668,172.45
51210	Өмнөх үеийн үр дүн	3,185,665,151.35	3,189,025,151.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,643,021.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,068,704,052.96	1,068,704,052.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,524,369,204.31</b>	<b>4,541,372,225.41</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,592,707,885.99</b>	<b>2,175,446,990.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,354,690.99</b>	<b>37,084,018.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,354,690.99	37,084,018.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	810,000.00	8,059,915.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	810,000.00	8,059,915.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	26,561,762.00	25,765,003.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,982,928.99	3,259,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,563,353,195.00</b>	<b>2,138,362,972.05</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,283,316,600.00</b>	<b>1,805,324,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	960,014,300.00	1,805,324,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,323,302,300.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,902,555.00</b>	<b>6,379,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,706,707.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,195,848.00	6,379,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>263,134,040.00</b>	<b>326,658,772.05</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	263,134,040.00	326,658,772.05

2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,739,641,060.08</b>	<b>2,159,026,421.53</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,739,641,060.08</b>	<b>2,159,026,421.53</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,681,537,400.08</b>	<b>1,989,783,751.53</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,074,525,698.34</b>	<b>1,321,481,394.54</b>
210101	Үндсэн цалин	647,414,645.34	936,408,119.41
210102	Нэмэгдэл	329,092,201.00	328,737,455.13
210104	Урамшуулал	98,018,852.00	56,335,820.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>142,522,538.76</b>	<b>167,258,976.61</b>
210201	Тэтгэврийн даатгал	110,438,120.44	114,629,149.99
210202	Тэтгэмжийн даатгал	8,265,738.83	13,504,562.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,522,991.56	10,860,012.62
210204	Ажилгүйдлийн даатгал	1,572,335.17	2,709,952.56
210205	Эрүүл мэндийн даатгал	15,723,352.76	25,555,299.40
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>254,134,040.00</b>	<b>271,075,435.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,306,052.00	13,290,919.60
210302	Түлш, халаалт	235,198,796.00	244,284,516.00
210303	Цэвэр, бохир ус	7,629,192.00	13,500,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,425,037.00</b>	<b>129,000.00</b>
210401	Бичиг хэрэг	9,911,693.00	129,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,030,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,434,280.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,040,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,264.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,800.00	-
2105	<b>Нормативт зардал</b>	<b>13,372,550.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	850,850.00	-
210502	Хоол, хүнс	12,521,700.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,625,099.00</b>	<b>11,127,150.00</b>
210604	Урсгал засвар	8,625,099.00	11,127,150.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>292,200.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	292,200.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,036,549.00</b>	<b>2,360,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,129,349.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,360,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>159,603,687.98</b>	<b>216,351,794.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	49,691,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,430,000.00	16,136,420.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,173,687.98	150,524,234.78
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,103,660.00</b>	<b>169,242,670.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,346,700.00</b>	<b>169,242,670.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,116,700.00	134,913,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,230,000.00	34,329,670.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,756,960.00</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,756,960.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>853,066,825.91</b>	<b>16,420,568.52</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,749,866.59</b>	<b>2,777,547.42</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,749,866.59	2,777,547.42
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(5,749,866.59)</b>	<b>(2,777,547.42)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>847,316,959.32</b>	<b>13,643,021.10</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,564,163,195.00</b>	<b>2,161,074,887.05</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>810,000.00</b>	<b>22,711,915.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>810,000.00</b>	<b>22,711,915.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>810,000.00</b>	<b>22,711,915.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	810,000.00	14,600,815.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,751,100.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	3,360,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,563,353,195.00</b>	<b>2,138,362,972.05</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,283,316,600.00</b>	<b>1,805,324,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	960,014,300.00	1,805,324,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,323,302,300.00	-
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,902,555.00</b>	<b>6,379,400.00</b>

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,706,707.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,195,848.00	6,379,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>263,134,040.00</b>	<b>326,658,772.05</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	263,134,040.00	326,658,772.05
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,579,168,995.00</b>	<b>2,039,088,290.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,579,168,995.00</b>	<b>2,039,088,290.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,521,876,835.00</b>	<b>1,869,845,620.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,074,547,619.00</b>	<b>1,321,050,553.28</b>
210101	Үндсэн цалин	658,940,071.00	935,977,278.15
210102	Нэмэгдэл	317,588,696.00	328,737,455.13
210104	Урамшуулал	98,018,852.00	56,335,820.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>141,922,434.00</b>	<b>167,212,781.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	106,283,134.00	114,629,149.99
210202	Тэтгэмжийн даатгал	8,909,800.00	13,458,366.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,127,900.00	10,860,012.62
210204	Ажилгүйдлийн даатгал	1,782,000.00	2,709,952.56
210205	Эрүүл мэндийн даатгал	17,819,600.00	25,555,299.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>254,134,040.00</b>	<b>271,075,435.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,306,052.00	13,290,919.60
210302	Түлш, халаалт	235,198,796.00	244,284,516.00
210303	Цэвэр, бохир ус	7,629,192.00	13,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,269,187.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	1,589,707.00	-
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,143,780.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,135,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,700.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,766,400.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,766,400.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,868,099.00</b>	<b>14,247,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	247,200.00
210604	Урсгал засвар	9,868,099.00	14,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>294,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	294,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,640,549.00</b>	<b>22,522,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,733,349.00	6,292,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	16,230,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,434,507.00</b>	<b>73,737,050.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	49,955,490.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,434,507.00	23,781,560.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,292,160.00</b>	<b>169,242,670.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,535,200.00</b>	<b>169,242,670.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,135,200.00	134,913,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	34,329,670.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,756,960.00</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,756,960.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>984,994,200.00</b>	<b>121,986,596.80</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>24,131,900.00</b>	<b>92,597,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>24,131,900.00</b>	<b>92,597,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>24,131,900.00</b>	<b>92,597,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	23,631,900.00	89,147,000.00
223001	Бусад хөрөнгө	500,000.00	3,450,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(24,131,900.00)</b>	<b>(92,597,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>960,862,300.00</b>	<b>29,389,596.80</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>29,389,596.80</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,000,000.00	1,068,704,052.96	3,189,025,151.35	4,527,729,204.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,189,025,151.35</b>	4,527,729,204.31
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	13,456,054.43	13,456,054.43
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,185,665,151.35</b>	4,524,369,204.31
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,185,665,151.35</b>	4,524,369,204.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,360,000.00	3,360,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,189,025,151.35</b>	4,527,729,204.31
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	13,643,021.10	13,643,021.10
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>270,000,000.00</b>	<b>1,068,704,052.96</b>	<b>3,202,668,172.45</b>	4,541,372,225.41

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,174,163,600.00	2,131,685,290.25	42,478,309.75
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,174,163,600.00	2,131,685,290.25	42,478,309.75
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,006,038,200.00	1,962,442,620.25	43,595,579.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,338,484,400.00	1,321,050,553.28	17,433,846.72
210101	Үндсэн цалин	980,288,500.00	935,977,278.15	44,311,221.85
210102	Нэмэгдэл	326,576,900.00	328,737,455.13	(2,160,555.13)
210104	Урамшуулал	31,619,000.00	56,335,820.00	(24,716,820.00)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	169,524,600.00	167,212,781.37	2,311,818.63
210201	Тэтгэврийн даатгал	115,276,800.00	114,629,149.99	647,650.01
210202	Тэтгэмжийн даатгал	13,562,000.00	13,458,366.80	103,633.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,849,600.00	10,860,012.62	(10,412.62)
210204	Ажилгүйдлийн даатгал	2,712,300.00	2,709,952.56	2,347.44
210205	Эрүүл мэндийн даатгал	27,123,900.00	25,555,299.40	1,568,600.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	281,578,600.00	271,075,435.60	10,503,164.40
210301	Гэрэл, цахилгаан	23,794,000.00	13,290,919.60	10,503,080.40
210302	Түлш, халаалт	244,284,600.00	244,284,516.00	84.00
210303	Цэвэр, бохир ус	13,500,000.00	13,500,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,232,200.00	-	1,232,200.00
210502	Хоол, хүнс	1,232,200.00	-	1,232,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,800,000.00	18,202,700.00	6,597,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,800,000.00	4,202,700.00	6,597,300.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	14,000,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,527,700.00	22,522,600.00	5,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,292,000.00	6,292,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,235,700.00	16,230,600.00	5,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	167,890,700.00	162,378,550.00	5,512,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,537,100.00	138,024,990.00	5,512,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,353,600.00	24,353,560.00	40.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	168,125,400.00	169,242,670.00	(1,117,270.00)
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	168,125,400.00	169,242,670.00	(1,117,270.00)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,465,700.00	134,913,000.00	1,552,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,659,700.00	34,329,670.00	(2,669,970.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,174,163,600.00	2,161,074,887.05	13,088,712.95
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,805,324,800.00	1,805,324,800.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,805,324,800.00	1,805,324,800.00	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	337,162,100.00	326,658,772.05	10,503,327.95
132001	Орон нутгийн төсвөөс	337,162,100.00	326,658,772.05	10,503,327.95
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	31,676,700.00	29,091,315.00	2,585,385.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,292,000.00	6,292,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,384,700.00	19,439,315.00	5,945,385.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		3,360,000.00	(3,360,000.00)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>29,389,596.80</b>	<b>(29,389,596.80)</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	93.00	93.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	77.00	-
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>6,379,400.00</b>
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,379,400.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>6,379,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>6,379,400.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,379,400.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 20.6 сая төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 20.6 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

#### Залруулсан алдаа:

1. Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулсан.
2. 8 байгууллагаас 4.2 сая төгрөгийн и-баримт аваагүй байсныг нөхөн авсан.
3. Сурах бичиг түрээслүүлсний 6.3 сая төгрөгийн орлого болон бусад түрээсийн орлогын 50 хувь болох 3.5 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг залруулсан.
4. 3.2 сая төгрөгийн эргэлтийн (түрээсийн) номыг үндсэн хөрөнгөнд бүртгэснийг залруулсан

Аудитаар нийт 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс 3 зөвлөмж, өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага хэрэгжээгүй, дахин давтагдсан тул удирдлагад 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 3.2 Албан шаардлага

##### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,746.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,009.9 сая төгрөгийн 48 гүйлгээ, 152.6 сая төгрөгийн 22 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.1 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.0 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.0 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.3 Зөвлөмж

##### 1. Засгийн газрын оруулсан капиталтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн “0” төгрөг, УБГэрчилгээ дээрх өмчийн дүн 270.0 сая байна. Энэ нь үнэн, бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл”-ийн “7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн” болон 14 дүгээр зүйлийн “14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын оруулсан капиталд өөрчлөлт оруулсан тохиолдолд өөрчлөлтийн талаарх бичиг баримтыг бүрдүүлэн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж мэдээллээ шинэчлэх.

## **2. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагын 3 ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь НД-ын байгууллагад үнэн зөв тайлагнаагүйгээс үүссэн зөрүүнд нөхөн шимтгэл, торгууль тавигдах үр дагавартай.

Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор” шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг нийгмийн даатгалын байгууллагад үнэн зөв тайлагнаж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

## **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актгүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20-р зүйлийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч жилийн тайланг гаргахын өмнө тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг тооцон, хянан, баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн	1	3,360.0			1	3,360.0	1	3,360.0				
8 байгууллагаас 4.2 сая төгрөгийн и-баримт аваагүй	1	4,276.3			1	4,276.3	1	4,276.3				
Түрээсийн номын 6.3 сая төгрөгийн орлого болон бусад түрээсийн 50 хувь болох 3.5 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн	1	9,751.1			1	9,751.1	1	9,751.1				
3.2 сая төгрөгийн эргэлтийн түрээсийн номыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1	3,189.1			1	3,189.1	1	3,189.1				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>20,576.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>20,576.5</b>	<b>4</b>	<b>20,576.5</b>	<b>-</b>	<b>-</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн "0" төгрөг, УБГэрчилгээ дээрх өмчийн дүн 270.0 сая байна.	1	-					1	-				
Тус байгууллагын 3 ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна.	1	188.6					1	188.6				
Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актгүй байна.	1	-					1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>188.6</b>					<b>3</b>	<b>188.6</b>				<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 2,746.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,009.9 сая төгрөгийн 48 гүйлгээ, 152.6 сая төгрөгийн 22 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.1 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.0 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.0 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-			
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>			